

# Баруун Нортфийлдийн сургуулийн 31-р дүүрэг болон QUEST

## Хоолний хөтөлбөр

2020 оны 10-р сарын 5-наас 12-р сарын 31-ний өдөр хүртэл



Бид 31-р дүүргийн бүх сурагчдадаа үнэгүй хоол өгөх болсоноо зарлаж байгаадаа их баяртай байна. Холбооны улсын санхүүжилтээр хэрэгжиж буй USDA-ийн Зуны хоолны хөтөлбөр программд талархал илэрхийлэе. Манай дүүрэг нь энэхүү хөтөлбөрт Ковидаас хамааран энэ жилийг дуустал түр хамрагдах болсон (нөхцөл байдлаас хамааран цааш сунгагдаж магадгүй). Энэ хөтөлбөрийн хугацаанд сургуулиас сурагчдад өглөө болон өдрийн хоолыг **үнэгүй** өгнө. Та бүхэн илүү дэлгэрэнгүй мэдээллийг манай дүүргийн цахим хуудсаар орон авна уу.

### **Танхимийн сургалтанд хамрагдаж байгаа сурагчдын өдрийн хоол.**

Бид бүх сурагчдыг энэхүү хөтөлбөрт хамрагдахыг уриалж байна. Эцэг эхчүүд үнэгүй өдрийг хоолний хөтөлбөрт бүртгүүлэх шаардлагагүй. Хичээлд ирж байгаа сурагч бүр үнэгүй хоол авах болно.

2020 оны 10-р сарын 5-ний өдрөөс эхлэн 31-р дүүрэг сургуулийнхаа бүх хүүхдүүдэд үнэгүй өглөө өдрийн хоолоор үйлчилнэ. Бид бүх гэр бүлүүдийг гэрээсээ хоол явуулалгүй уг хөтөлбөрт хамрагдахыг хүсч байна. Та хүсвэл гэрээсээ хоол өгч явуулж болно. Сүү үнэгүй байна.

Холбооны улсын шаардлагын дагуу хоол бэлтгэн нийлүүлэгч Quest хоолны сонголт, хэмжээ зэргийг санал болгох боломжгүй.

### **Алсын зайн сургалтанд хамрагдаж байгаа сурагчдын өдрийн хоол**

31-р дүүргийн алсын зайн сургалтанд хамрагдаж байгаа сурагчид мөн энэ хөтөлбөрт хамрагдан 7 хоногийнхоо хоолыг нэг дор авах боломжтой. Алсын зайн сургалтанд хамрагдаж байгаа сурагчдын эцэг эхчүүд уг хөтөлбөрт хамраглах эсээ анкет бөглөн хоол тараах газраас ирж авах эсвэл гэртээ хүргүүлэх хүсэлтээ сонгож мэдэгдэнэ. Бүртгүүлсэн сурагч бүр 7 ширхэг өглөөний болон өдрийн хоол хүлээн авна.

1. Гэр бүлүүл хүнсийг **Glenbrook South** ахлах сургуулийн **H** хаалган дээрээс **8:30-12:00** цагийн хооронд **Даваа гараг бүр 10-р сарын 5-ний өдрөөс эхлэн авна.** (Олон нийтийн амралтын өдөр таарвал тухайн 7 хоногийн **Мягмар гарагт**)

**Эсвэл**

2. **North Shore Transit-ийн түгээлтийн машинаар Даваа гарагт гэртээ хүргүүлэн авах боломжтой**

**Хэрвээ танай хүүхэд алсын зайн сургалтанд хамрагдаж байгаа болон та уг хоолны хөтөлбөрт хамрагдахыг хүсвэл дараах анкетийн бөглөн өгнө үү.**

- [Request for Delivery of Meals - English](#)
- [Request for Delivery of Meals - Spanish](#)
- [Request for Delivery of Meals - Mongolian](#)

- [Request for Delivery of Meals - Korean](#)

### **Бусад мэдээлэл**

- Зарим хүүхдүүд цардуулгүй, цагаан хоол идэх шаардлагатай байдаг ба хэрвээ та ийм шаардлагатай байгаа бол дараах анкетийн бөглөнө [Хоолны дэглэмийн хүсэлт](#) (эндээс асуулт хариулттай танилцана уу). Quest Food Management хүнс бэлтгэн нийлүүлэгч маань бүх шаардлагад нийцүүлэн хүнсийг бэлтгэнэ. Бид газрын самар болон бусад самрын төрлийг гал тогоондоо хэрэглэдэггүй. Гэхдээ та манайхаас авсан хүнсний орцын мэдээллийг давхар шалгаарай. Хүнсний бүтээгдэхүүн нийлүүлэгч нар мэдэгдэлгүйгээр орцын бүтцийг өөрчлөх магадлал байдаг тул та бүхэн шалгах хэрэгтэй. Хэрвээ таньд ямар нэг асуулт байвал [garellano@questfms.com](mailto:garellano@questfms.com) хаягаар холбогдоно уу.
- FD Planner App дээр амин дэмийн мэдээлэл байгаа
- Та бүхэн манай цахим хуудсаар зочлон хоолны цэс, хоолны төлөвлөлт болон асуулт хариулт зэрэг мэдээллийг авна уу!

**Бидний хамгийн эцсийн мэдэгдэл: Хоол Glenbrook South ахлах сургууль дээр Талархлын баяр болон өвлийн амралтын 2 долоо хоног мөн Даваа гараг бүр тараагдана.**